

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Гоо зүйн боловсролын багшийн хөгжил хариуцсан арга зүйч, мэргэжилтэн / Хөгжмийн боловсрол / , Жамъянхорол Ууганцэцэг

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.1. 1.1. 1.1. Багш, ажилтны мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж, мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэх							
1	Ментор багш нарыг бэлтгэж, Ментор хөтөлбөр хэрэгжүүлэх.	Ментор багш нарын тоо, хэрэгжүүлсэн хөтөлбөр	Бэлтгэгдсэн ментор багш-33	-	2024-2025 оны хичээлийн жилд хэрэгжүүлж буй Менторшип хөтөлбөрийн үргэлжлэл 25 Ментор багш бэлтгэх хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах бэлтгэл ажил хийгдэж байна. Энэ ажлын хүрээнд хөтөлбөр боловсруулах эхний зураглал гарч сургалтын агуулгын зураглал болосруулж байна. Үндэсний "Ментор багш бэлтгэх хөтөлбөр"-т хамрагдах зорилтот бүлгийн судалгаа хийх ажил эхэлсэн. Уг хөтөлбөрийг 9 дүгээр сард боловсруулж дуусган багш бэлтгэх сургалт 10 дугаар сард эхлүүлэхээр	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	50%

					төлөвлөж байна.		
2	Ерөнхий боловсролын сургалтын байгууллагын хүний нөөцийн хөгжлийн чиглэлээр батлагдсан хууль, тогтоомж, шийдвэр, бодлогын баримт бичиг, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах	Дүрэм, журмын хэрэгжилтийг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо, батлагдсан удирдамж, тайлан	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын 950 захирал, эрхлэгч нарт сургалт зохион байгуулсан	2-оос доошгүй үйл ажиллагааг хамтран зохион байгуулж, тайлагнана.	2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр Монголын морин хуурын холбооны төлөөлөл-4. БСҮХ-1, БЕГ-1, СУИС-1 төлөөлөл нийт 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр ерөнхийлөгчийн зарлиг болон 59-р тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөөнд хамтрах уулзалтыг зохион байгуулсан. Энэхүү ажлаар БЕГ болон БСҮХ урьдчилан төлөвлөөд байгаа төслөө танилцуулан санал авав. - 2025 оны 2 дугаар сарын өдөр Монгол улсын хэмжээнд морин хуурын сургалтыг зохион байгуулдаг нийт багш нарын төлөөлөл 32 морин хуурын багш МХО-ны бага зааланд уулзаж ерөнхийлөгчийн зарлиг болон 59-р тогтоолын хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг хэлэлцэв. Нийт 8 хүн төлөвлөгөөнд тусгах, өөрчлөх санал хүргүүлэв. Уулзалтаар БЕГ, БСҮХ, ММХБНХ хамтран зохион байгуулав. -2025 оны 02 дугаар сарын эхний 7 хоногт Морин хуурыг заах боломжтой нийт багш нарын судалгааг гаргахаар аймаг, нийслэлийн БГ-уудад хүргүүлэн нэгтгэн авсан	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					болно. Үүнд: Улсын хэмжээнд морин хуурын сургалтыг явуулдаг нийт 282 багш зохион байгуулж байгаагаас 252 нь хөгжмийн багш байна. Мөн морин хуурын сургалтыг 0-4 жилдээ зохион байгуулж байгаа 175 багш, 5-15 жилийн 85 багш, 16-с дээш жил ажиллаж байгаа 21 багш байна. Хөгжмийн анги танхимын хувьд 186 багш сургалт зохион байгуулах танхимтай байгаа бол 96 багшид тогтсон анги танхим байхгүй байна. Уг судалгаанд морин хуур хөгжмийг суралцаад заах хүсэлтэй 290 багш хүсэлтээ ирүүлснээс 251 багш мэргэжлийн багш байна. - Ерөнхийлөгчийн зарлаг болон 59-р тогтоолын хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөөг батлуулах, төслийг хэлэлцүүлэх, удирдамжийг боловсруулах ажил хийгдэж байна.		
3	Дүрэм, журмын хэрэгжилтийг хангах чиглэлээр 1200 сургалтын байгууллагын удирдах ажилтнуудад чиглэсэн 3-аас доошгүй үйл	Батлагдсан төсвийн хүрээнд	Үндсэн сургалтад хамрагдсан нийт багш -160	2-оос доошгүй үйл ажиллагааг хамтран зохион байгуулж, тайлагнана.	2025 оны 03 дугаар сарын 23-ний өдрөөс 05 дугаар сарын 09-ны өдрийг дуустал 56 цагийн сургалт танхим болон цахим сургалт зохион байгуулсан. Танхимын сургалтад ЕБС-ын хөгжмийн 131 багш хамрагдсан бол	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р	100%

	ажиллагаа зохион байгуулж, тайлагнасан байна				цахим сургалт Bagsh.edu.mn талбар дээр амжилттай зохион байгуулагдаж 127 багшаас 99 багш буюу 77% нь амжилттай суралцаж батламж авсан байна. Багш нар танхимын сургалтаар судалсан материал, бичсэн эргэцүүлэлдээ тулгуурлан бусадтай санал солилцох, ажилдаа тусган хэрэгжүүлсэн үр дүнгээр гурваас доошгүй удаа эргэцүүлэл бичиж эргэцүүлэл суурилсан хэлэлцүүлэг хийсэн нь үр дүнтэй байлаа. Цахим сургалтаар багш нар дэлхийн иргэний боловсрол, ТХБ-ын сэдвүүдээс нэгийг сонгон судалгаат хичээл зохион төлөвлөсөн интеграци хичээлийн арга зүйгээр хичээл төлөвлөн заасан бөгөөд Дархан-Уул аймгийн Од сургуулийн хөгжмийн багш Ц.Ичинхорлоогийн сайн туршлагыг БЕГ-ын пэйж хуудсаар дамжуулан түгээсэн болно. Хавсралт: 3 файл	сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
4	Багшийн хөгжлийг дэмжих платформд суурилсан цахим сургалтын сан бүрдүүлэхэд хамтарч	Платформд байршуулсан шаардлага хангасан цахим сургалтын тоо,	0	4 модуль	Багш, ажилтан, байгууллагын хөгжлийн газраас сургалтын байгууллагын багш, удирдах ажилтан өөрсдийн хөгжлийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р	100%

	ажиллах	чанар			хэрэгцээнд үндэслэн цаг хугацаа, орон зайнаас үл хамааран суралцах боломж бий болгох зорилт тавин ажиллаж байна.Багшийн хөгжлийг дэмжих Bagsh.edu.mn платформд суурилан суралцах боломжтой болж байна.Боловсролын ерөнхий газраас 2023-2024 оны хичээлийн жилд зохион байгуулсан модуль сургалтын үр дүнгийн судалгаа, мониторингоос багш нараас хамгийн өндөр үнэлгээ авсан 12 модулийг сонгож, боловсруулсан багтай гэрээ байгуулан БЕГ-ын өмчид авсан.Манай байгууллага гэрээний дагуу тус 12 модулийг ашиглан сургалт зохион байгуулах эрхтэй. Багшийн хөгжлийн Bagsh.edu.mn платформд 12 модулийг байршуулсан бөгөөд багш нар сонголтоороо үнэ төлбөргүй судалж, амжилттай төгсвөл батламж авах боломжийг бүрдүүллээ. Хавсралт: 1 файл	сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
5	Багш солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх.	Хөтөлбөрийн батлагдсан удирдамж, төлөвлөгөө, оролцогчдын	Сургалтын байгууллага-15, багш -20	-	2025 оны 2 дугаар хагаст гүйцэтгэх ажил.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р	0%

		тоо, чанар				сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
6	Ерөнхий боловсрол, сургалтын байгууллагын багшид мэргэжлийн “Зөвлөх” зэрэг олгох дүгнэлт гаргах	Дүгнэлт гаргасан материалын тоо	Бэлтгэл ажил хангах	161 багшийн дүгнэлт	2025 оны 2 дугаар хагаст гүйцэтгэх ажил.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	0%
7	Сургалтын байгууллагын “Мэргэжлийн хөгжлийн бүлэг”-ийн үйл ажиллагаанд зөвлөн тусалж, үндэсний хэмжээнд тайлант өдөрлөг зохион байгуулж, үр дүнтэй МХБ-ийн сан бүрдүүлэх.	Зөвлөн тусалсан МХБ-ийн тоо, үр дүнтэй МХБ-ийн тоо	БЕГ-аас баталсан аргачлал, чиглэл, тайлант өдөрлөг зохион байгуулах удирдамж, сургалтын байгууллагын МХБ-үүд ажиллах удирдамж	3-4 сургалтын байгууллагын МХБ	Нийслэлийн БЗД-ийн 87, чингэлтэй дүүргийн 57, Багахангай дүүргийн 92,94-р сургуулиудын МХБ- зөвлөн тусалж ажиллалаа. Сургууль, багш нар гүйцэтгэлийн болон өөрийн үнэлгээний үр дүнгээр сул гүйцэтгэлтэй үр дүнд шинжилгээ хийсний үндсэн дээр бүлгээр ажиллах асуудлаа тодорхойлон хамтран ажиллахад нь чиглүүлсэн болно. Мөн Нийслэлийн ЕБС-ын 156 сургуулиас мэргэжлийн багшийн бүлгийн үйл ажиллагааны үр дүнг	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					асуулгаар авахад багшийн хөгжлийн төвтэй сургууль 141, төвгүй 15 сургууль байна. Багшийн хөгжлийн төлөвлөгөөний 60 орчим хувийг мэргэжлийн багш нарын бүлгийн үйл ажиллагаа эзэлж байна. Сургуульд дунджаар 5 мэргэжлийн багш нарын бүлэг ажиллаж байна. Мэргэжлийн багш нарын бүлгээр бүх багш нар хамрагддаг болсон. Багшийн хөгжлийн сургалтын менежер дунджаар 1-5 мэргэжлийн багш нарын бүлгийг чиглүүлж ажиллаж байна. Цаашид сургалтын менежерийг МХБ-ийг чиглүүлэн ажиллахад дэмжлэг үзүүлсэн үйл ажиллагааг түлхүү зохион байгуулах шаардлага байна. Хавсралт: 3 файл		
8	Хамтын ажиллагаа, санамж бичгийн хүрээнд гадаад улсын Боловсролын газартай туршлага солилцох үйл ажиллагаа зохион байгуулах	Туршлага солилцсон албан хаагчийн тоо, үр дүн	6 албан хаагч хамрагдсан	-	БЕГ болон Япон улсын Шизуока мужийн боловсролын газар, "Асүнаро" багшийн хөгжлийн төвтэй хамтарсан туршлага солилцох үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах, бэлтгэл хангах хөтөлбөр боловсруулахад санал оруулсан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар,	50%

						сар	
9	ЕБС-ийн багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалтаас бусад олон талт (эрдэм шинжилгээний болон онол практикийн бага хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэг, түншлэл, хамтын үйл ажиллагаа) ажлыг зохион байгуулах.	Сургалт, үйл ажиллагааны батлагдсан хөтөлбөр, удирдамж, тайлан, оролцогчдын тоо	Сургалт-8, оролцогч-1211	3- аас доошгүй үйл ажиллагаа	- Шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлтгэл хангах менежментийн зураглал боловсруулах уулзалт-хэлэлцүүлэг: Аймгийн төвд 3 дугаар сарын 17, 18-ны өдрүүдэд Боловсролын ерөнхий газрын мэргэжилтнүүд аймгийн Боловсролын газрын Сургалт, арга зүйн хэлтсийн дарга, СӨБ, Бага боловсрол хариуцсан мэргэжилтнүүд, туршилтын сургууль, цэцэрлэгийн удирдлага, туршилтад хамрагдаагүй сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгчийн төлөөлөл оролцсон. Туршилт хэрэгжүүлж буй сумын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нар сумаас аймгийн төвд ирж оролцсон бөгөөд туршилтын сургууль, цэцэрлэгүүдэд зөвлөн туслах үйл ажиллагаа, боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн удирдамжийн дагуу 3 дугаар сарын 17-21-ний өдрүүдэд тухайн сургууль, цэцэрлэгүүд дээр зохион байгуулагдсан. Энэхүү ажлын хүрээнд Сүхбаатар аймгийн Боловсролын	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					газарт 03 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд ажилласан болно. - Шинэчилсэн хөтөлбөрийн хүрээнд хөгжмийн багт ажилласан бөгөөд энэ ажлын хүрээнд Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын 3-р сургууль, "Мөнххаан" сумын ЕБС, Нийслэлийн Налайх дүүргийн "Боловсрол сургууль"-д 2,3,4- дүгээр сурагдад тус тус ажиллаж, гарын авлага, дасгал ажлын дэвтрийн тохирцыг туршсан болно. Хавсралт: 2 файл		
10	Ерөнхий боловсролын сургуулийн багшийн хөгжил хариуцсан сургалтын менежерүүдийг чадавхжуулах сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах.	Сургалтын батлагдсан удирдамж, хөтөлбөр, төлөвлөгөө оролцогчдын тоо, хувь	0	690 сургалтын менежер	Ерөнхий боловсролын сургуулиудын багшийн хөгжил хариуцсан сургалтын менежерийн мэргэжлийн хөгжлийг дэмжих, чадавхжуулах сургалтыг Багшийн хөгжлийн тухай хууль, Алсын хараа-2050 Монгол улсын урт хугацааны бодлого, Багшийн гурван тулгуурт бодлого зэрэг баримт бичгүүдийг үндэслэл болгож Боловсролын яам, Боловсролын ерөнхий газраас ерөнхий боловсролын сургуулийн багшийн хөгжил хариуцсан сургалтын менежерийн мэргэжлийн хөгжлийг	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					дэмжих, онол арга зүйн мэдлэгийг дээшлүүлэх, улмаар сургалтын байгууллагын багшийн хөгжлийн төвийг хөгжүүлэх, төвийн үйл ажиллагаанд тулгуурлан, багш нарыг ажлын байранд хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИУДЫН БАГШИЙН ХӨГЖИЛ ХАРИУЦСАН СУРГАЛТЫН МЕНЕЖЕРИЙН МЭРГЭЖЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ, ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТ”-ыг 2025 оны 2 дугаар сараас 05 дугаар саруудад зохион байгуулсан. Танхимын сургалтаар Дархан-Уул аймгийн 25 менежер, Дундговь аймгийн 23 сургалтын менежерт сургалтыг зохион байгуулж ажиллсан болно. Хавсралт: 7 файл		
11	Орон нутгийн байгууллагын хөгжмийн судлагдахуун хариуцсан арга зүйч нарын чадавхыг дээшлүүлэх сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах.	Сургалтын батлагдсан хөтөлбөр, удирдамж, тайлан хамрагдсан хүний тоо, хувь	Сургалт-2, оролцогч-128	50%-ийг хамруулсан байна.	Аймаг, нийслэлийн БГ-ын судлагдахуун хариуцсан арга зүйч нарын чадавхыг дээшлүүлэх сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах ажил одоогоор 2025 оны 10 сард эхлэхээр хойшлогдоод байна.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар,	20%

						сар, 12-р сар	
3.1. 3.1. Нэгжийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг мөрдөн ажиллах							
12	Ерөнхий газрын даргын шуурхай хурал, даргын зөвлөлийн хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах	Биелэлт /хувь/	100%	50%	- Шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлтгэл хангах менежментийн зураглал боловсруулах уулзалт-хэлэлцүүлэг: Аймгийн төвд 3 дугаар сарын 17, 18-ны өдрүүдэд Боловсролын ерөнхий газрын мэргэжилтнүүд аймгийн Боловсролын газрын Сургалт, арга зүйн хэлтсийн дарга, СӨБ, Бага боловсрол хариуцсан мэргэжилтнүүд, туршилтын сургууль, цэцэрлэгийн удирдлага, туршилтад хамрагдаагүй сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгчийн төлөөлөл оролцсон. Туршилт хэрэгжүүлж буй сумын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нар сумаас аймгийн төвд ирж оролцсон бөгөөд туршилтын сургууль, цэцэрлэгүүдэд зөвлөн туслах үйл ажиллагаа, боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн удирдамжийн дагуу 3 дугаар сарын 17-21-ний өдрүүдэд тухайн сургууль, цэцэрлэгүүд дээр зохион байгуулагдсан. Энэхүү	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					ажлын хүрээнд Сүхбаатар аймгийн Боловсролын газарт 03 дугаар сарын 17- 18-ны өдрүүдэд ажилласан болно. Хавсралт: 4 файл		
13	Архив, албан хэрэг хөтлөлтийн журмыг хэрэгжүүлж, эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, тайлан, холбогдох материалыг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын нэгж болгон хадгалуулах	Архивт хүлээлгэн өгөх баримтын тоо	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу боловсруулсан шаардлагатай баримт бичгийг архивт өгөх	50%	2024 оны үндсэн сургалт болон модуль сургалт, 2024 оны "Зөвлөх багш"-тай холбоотой бүх бичиг баримтыг архивд хүлээлгэн өгсөн.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
14	Авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх	Биелэлт /хувь/	100%	50%	Авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан чиг үүргийг ажилдаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Байгууллагын ёс зүйн хорооны авилгын эсрэг хууль, дүрмийн хэрэгжилтийг ханган ажиллахад анхаарч холбогдох хууль, дүрэм, гарын авлага уншиж судалж байна.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Байгууллагын хүний нөөцийг чадавхжуулах дотоодын сургалтуудад хамрагдах	Байгууллагын хүний нөөцийг чадавхжуулах дотоодын сургалтуудад хамрагдах	100%	100%	- Байгууллагаас зохион байгуулсан 4 удаагийн сургалтад цахим болон танхимаар хамрагдсан - МУБИС Докторант ангид суралцаж байна - 2025 оны 03 сард "Сургалтын байгууллагын багшийн хөгжил хариуцсан менежерийг чадавхжуулах" сургалтын сургагч багшаар бэлтгэгдсэн. Хавсралт: 1 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
2	Ажил үүргийн холбогдолтой шинээр батлагдсан хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийг судлах	Судалсан хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийг судална	100%	100%	Боловсролын сайдын 2025 оны А/25 тоот тушаалаар батлагдсан Мэргэжил дээшлүүлэх сургалт, үйл ажиллагааны журам, сургалтын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/106 дугаар тушаал, зэргийг судлан ажилдаа тусган хэрэгжүүлж байна.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Гоо зүйн боловсролын багшийн хөгжил хариуцсан арга зүйч, мэргэжилтэн / Хөгжмийн боловсрол / , Жамъянхорол Ууганцэцэг
/...../ Огноо: